# Малын тэжээлийг зөв хэмжихэд бүх нийтээр анхааръя

Малын тоог олшруулах, үүлдрийн чанарыг сайжруулан ашиг шимийг нэмэгдүүлэхэд сайн чанарын арвин тэжээл гол нөхцөл нь болдог.

Манай аймаг 1967 онд таримал тэжээл 22,3 байгалийн хадлан 79,7 мянган тонныг бэлтгэсэн нь техникийн даацаар ачихад «ЗИЛ» машин 25,5 мянга орохоос үзэхэд ихээхэн хэмжээний хүч хөдөлмөр гаргаж үйлдвэрлэсэн нөөц хуримтлал болох нь илэрхий.

Малын тэжээл бэлтгэхэд жилд 6 сая төгрөг зарж байгаагийн 50 гаруй хувь нь байгалийн хадланд зориулагдаж байна.

Энэ байдлаас үзэхэд малын тэжээл нь зөвхөн байгалиас заясан хайр хишиг биш, асар их хөрөнгө хөдөлмөр зарцуулж бүтээсэн үнэт баялаг, социализмын материаллаг баазын биет хэсэг мөн.

Малын тэжээлийг бэлтгэхээс нь эхлэн зөв хэмжих, бүртгэх, зарцуулалтыг хувиар, төлөвлөгөөтэй зохицуулах чухал зорилт орон нутгийн нам, улс, ХАА—н байгууллагын бүх удирдлага, мэргэжилтэн, эдийн засагчид, статистикчид, санхүүгийн ажилтны хойшлуулшгүй үүрэг болж байна.

Аймгийн АДХ—ын чуулганаар батлагдсан «Өвс хадлагийн ажлыг зохион явуулах удирдамж», БНМАУ—ын Сайд нарын Зөвлөлийн дэргэдэх Статистикийн Төв Газрын баталсан «ХАА—н улсын мэдээллийн маягтуудыг нөхөх заавар»-уудын заалтыг малын тэжээл хэмжих, бүртгэх мэдээлэхэд хатуу баримтлах ёстой.

Таримал тэжээл нь биет жин, савны багтаамжаар ихэвчлэн тодорхойлогдох учир алдаа багатай хэмжигддэг байхад багтаамж жинг тусгай тогтоосон коэфицент томъёоны аргаар тодорхойлдог, хадлан сүрлийг хэмжихэд мэргэжил, дадлагын алдаа гаргаж буруудах явдал байна.

Бага ажиллаад их дүн гаргах сонирхол ч хадланг зөв хэмжих бүртгэх аргыг будлиантуулж байна.

3 сумын 1967 оны хадлангаа хэмжиж бүртгэсэн байдал

| Сумдын нэрс | Өвс тонн | | |
|---|---|---|---|
| | сумын захиргааны мэдээгээр | нэгдлийн хөрөнгөнд орлого болгосноор | малын тэжээлийн тооллогоор |
| Баянзүрх | 7268 | 1836 | 2410 |
| Дэлгэрхаан | 2506 | 625 | 610 |
| Бүрэн | 2500 | 1212 | 1212 |

Энэ сумдын бэлтгэсэн өвс 4,2 тонн байхад нэгдлийн хөрөнгөнд 3,6 мянгаар орлого авч улсад 12,2 мянгаар мэдээлэх нь хэнд хэрэгтэй байгаад дүгнэлт хийх хэрэгтэй юм.

Хадсан өвс сүрлийг хэмжих, бүртгэх, мэдээлэх ажлыг гардан хийх, хариуцан хянах, удирдах бүх хүмүүс батлагдсан удирдамж зааврuudыг бүрэн ойлгож, ялангуяа бага өвсийг их болгон худал хуурмаг мэдээлэх явдлыг бүрэн зогсоох хэрэгтэй.

Хадсан талбайг зөв хэмжих, нэг га-гийн дундаж ургацыг тодорхойлон тооцсоноор аж ахуйн дотоод хадлангийн явцыг удирдах зохицуулах явдлыг эдийн засгийн мэдлэгтэй шийдвэрлэж байх юм.

Харин улсын тайлан мэдээний гүйцэтгэлд оруулах, хөрөнгийн бүртгэлд авахад заавал хураан авсан (нуруулдсан, цуглуулж овоолсон, боосон) сайн чанарын өвс сүрэл орох болно.

Нуруулдсан, овоолсон өвсний хэмжээг тодорхойлоход зааврын дагуу куб метрийг зөв тогтоох, өвсний чанарыг уг нутгийн байгалийн бүсэд тохируулах, нуруулдсан буюу овоолсоноос хойших хоногийг мэдэх явдал гол шаардлага юм.

Боосон өвс, сүрлийн нэг боодлын дундаж жинг нарийн тогтоож, боодлын тоог баримтлан нийт хэмжээг тогтооно.

Тээврийн машинаар зөөсөн өвсний хэмжээг техникийн даацаар тооцсоноос эцэст нь хэмжихэд буруудагийг анхаарах хэрэгтэй.

Бэлтгэсэн сүрэл, өвсийг улсын мэдээ,хөрөнгийн бүртгэлд оруулах анхны баримтыг хадлангийн бригадад зориуд томилогдсон дарга, тоо бүртгэгч хариуцан гаргах эрх, үүрэгтэй.

САА, МААМС; ХАА—н нэгдлийн санхүү нь хадлангийн бригадынхаа дарга, тоо бүртгэгч нараас авсан өвсийг нь нарийн хэмжиж тодорхой актаар өөрсдийн эд хариуцагчдад өгч хүн нэг бүрийн хөдөлмөрийн хэмжээ, ажлын хөлс,бусад зардлыг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд тохируулан тооцоо бодох ёстой байна.

Бэлтгэн авсан тэжээлийг улсын мэдээний гүйцэтгэл, хөрөнгийн бүртгэлд зөв тусгах талаар сум хороодын АДХГ Захиргаад тодорхой хяналт тавих ёстой.

Малын тэжээлийг зөв хэмжиж бүртгэх нь энэ томоохон компанит ажлын үр дүнг зөв тодорхойлж хуурч мэхлэх явдалтай шийдвэртэй тэмцэх зэвсэг учир бүх нийтээрээ анхааръя!

**Ө.Хаянхярваа**

## Хүүхдийн хүмүүжилд

# Тоглоом хялбар хийх арга

Төрөл бүрийн хуванцар тоглоомын гадуур нь чихрийн зөөлөн цаасыг норгож наагаад дараа нь жирийн цагаан цаас жижиглэн 3-5 давхар наах хэрэгтэй.

Ингээд уг наасан зүйлээ гүйцэт хатсаны дараа яг тэхголоор нь зүсэж, анхны хэв болгосон хуванцар тоглоомоо аваарай.

Тэгээд зүсэж огтолсон 2 хэсгээ хооронд нь эвээр нь нийлүүлж мараль буюу нимгэн цагаан даавуугаар наах хэрэгтэй. Ингэсний чинь дараа яг нөгөө хуванцар тоглоом шиг хэлбэртэй тоглоом хийгдсэн байх болно.

Харин үүний дараа хуванцар тоглоомоо дууралган өнгө тохируулан будаж олифдах хэрэгтэй.

Ингээд л шинэ тоглоомтой болох нь тэр.

Ийм маягаар хэд хичнээн, ямар ч тоглоом хийж болно шүү дээ.

## ТОВЧХОН

Баянцагаан сумын намын үүрийн орлогч дарга Дэмбэрэл, гэргий Цэгмэд, цахилгаанчин Гомбо, усчин Лхам нарын хамт урт нь 45 метр, өргөн нь 8 метр төлийн 2 пүнзтэй бод малын хашаа барих амлалт авч ажиллаад түүнээ дуусгах гэж байна.

**Г.Дэмидмаа**



Ажилд санаачлага идэвхтэй энэ охиныг Лхагва гэдэг.

Лхагва тус сонины үйлдвэрт үсэг өрөгчөөр 3 дахь жилдээ ажиллаж байгаа ба сар улирлын төлөвлөгөөгөө тогтмол 105-110 хувиар биелүүлж, үйлдвэрийн тэргүүний ажилчны нэгд тоологдох болсон юм.

МХЗЭ—ийн гишүүн энэ охин 1968 оны 7 дугаар сарын төлөвлөгөөг 102,7 хувиар биелүүлсэн амжилтаар МХЗЭ—ийн 47 жилийн ойг угтаж байна.

## *ЖОЛООЧ*

Шинжлэх ухаан техник асар их хурдцаар хөгжиж өндөр бүтээл, их даац, хурд бүхий машин, техник өсөн нэмэгдсээр байна. Манай орны уудам их их тал нутагт машины хүч туслалцаа хүрэлцээгүй ямар ч байгууллага хүн байхгүй билээ.

Улс ардын аж ахуй, соёлын хөгжилтөд техник жолооч хоёрын үүрэг хариуцлага үлэмж их юм.

Авто тээвэрчид улс ардын аж ахуй, соёлыг хөгжүүлэх 4 дүгээр таван жилийн төлөвлөгөөг зориг бадрангуй хүлээн аваад чармайлттай ажиллаж байна.

Энэ таван жилд бүх авто машины тоо 33,8 хувиар нэмэгдэж, ачааны авто машины 50 гаруй хувь нь чиргүүлтэй болно.

Ачаа тээврийн талаар тавигдсан энэ зорилтыг биелүүлэгчид нь жолооч нар юм.

Авто машины жолооч нар цаг үеийн ямар ч хүнд нөхцөлд өмнөө тавьсан үүргээ амжилттай биелүүлж улс эх орондоо хүндтэй үүргийг гүйцэтгэж ирлээ.

Жолооч нарын эгнээнээс амжилт, бүтээл нь орон даяар цуурайтсан хөдөлмөрийн баатар, аврага тээвэрчид, Ардын Их Хурлын депутатууд, төрийн дээд шагнал хүртэгсэд олон тоогоор төрөн гарлаа.

Бумтны хөдөлгөөн мянга мянган жолоочыг хаммарч улмаар саятны өргөн их хөдөлгөөн өрнөж байна.

Гэвч тээврийн байгууллагын зарим ажилтан, жолооч, засварчдын үйл ажиллагаа хангалтгүй байгаагаас янз бүрийн саатал их гарч авто машин нэг бүрийн бүтээлийг бууруулж, зардлын хэмжээг өсгөх үндэс болж байгаа юм.

Иймээс 4 дүгээр таван жилд тээвэрчин, засварчдын өмнө тулгарч байгаа үндсэн зорилтын нэг бол авто машин техникийн ашиглалтыг дээд зэргээр сайжруулах явдал мөн.

Энэ зорилтыг биелүүлэх нь жолооч нэг бүрийн хувийн хариуцлага идэвх чармайлт, төлөвлөгөөт зорилтоо хир зэрэг ойлгосноос шалтгаалах болно.

Жолооч бүхэн авто машины сул зогсолтын хэмжээг багасгаж түүний бүтээлийг өндөржүүлэн төлөвлөгөөг сар улирал жилээр жигд хангаи биелүүлэхийн тулд их ажил хийх хэрэгтэй байна.

Манай жолооч нар аагим халуун,тэсгэм хүйтэн, нүдгүй шуурга зэрэг ямар ч бэрхшээлийг даван туулж зорьсондоо хүрдэг тэсвэр хатуужилтай ган зоригтнууд билээ.

Тэд улсдаа ихийг бүтээхийн зэрэгцээгээр олон давхар үүрэг хариуцлага хүлээж явдаг. Үүнд:

—Ачааг хүлээн авч тушааж байхдаа нярав, грушик,

—Замд гарсаны дараа жолооч, засварчин,

—Ачаа барааг тушааж гүйцэсний дараа ня-бо,тоо бүртгэгч,

—Замд хонох үед манаач, сахиул,

—Олон мянган төгрөгийн техник, материал хариуцаж явдагийн хувьд эд гардагч. Ийм үүрэгтэй гээр эх орныхоо өнцөг булан бүрт явж ажилладаг өндөр итгэл найдвар хүлээсэн хүмүүсээ.

Жолооч хүний ажилд орон нутгийн байгууллага хүмүүсээс тээврийн үүргээ биелүүлэхэд нь үлэмжийн туслалцаа үзүүлж тэднийг халамжлан хайрлаж ачаа барааг нь түргэн олгох, хүлээн авах, баримт материалыг нь шуурхай бүрдүүлж өгөх, ажлын явцад хяналт тавьж байх нь улс ардын аж ахуйн төлөвлөгөөг биелүүлэх явдалд асар их түлхэц өгөх ач холбогдолтой юм.

Одоо үр тариа хураан авах их ажил ид эхлэх боллоо.

Цаг мөч алдалгүй шуурхайлан хураах, тээвэрлэх үүрэг жолооч нарт урьдын адил оногдож байна.

Энэ их ажлыг хугацаанд нь чанар сайтай гүйцэт гэхэд тээвэрчдийн хувийн бэлтгэл, техникийн бүрэн бүтэн байдал засварын чанарыг хангаж ажлын хувийн төлөвлөгөө графикаа төлөвлөн тооцож, тариа хураалт, тээвэрлэлтийн явцад өчүүхэн ч саатал гаргахгүйгээр бүрэн бэлт гэж эрч хүчтэй ажиллах явдал тээвэрчдийн нэн тэргүүний чухал зорилт болж байна.

**Н. Дагва**